


FACE TO FACE – НҮҮР ТУЛСАН ЯРИЛЦЛАГЫН АРГА



Судалгаанд оролцогчоос биечлэн судалгааны асуултыг асууж, хариулт авах байдлаар явагддаг судалгааны аргачлал юм. Уг аргачлалын үеэр судлаач судалгаанд оролцогчоос асуултаа асуун, хэлсэн хариултыг бичиж тэмдэглэдэг. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогч судалгааг өөрөө бөглөхгүй юм. Уг аргачлалд судалгааны асуултын хариултаудыг судалгаанд оролцогчдод тусгай үзүүлэн карт байдлаар бэлтгэж өгдөг. Үзүүлэн карт нь цаг хэмнэхээс гадна, судалгаанд оролцогчид хариултаудаас сонгоход илүү дөхөм, хялбар байдаг. Нүүр тулсан ярилцлагын аргачлал нь судалгаанд оролцогчоос чанартай мэдээлэл цуглуулахад илүү давуу талтай юм.